

## ХОВД АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООНД ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-д заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох баримт бичгээ бүрдүүлж, [ganbold@khovd.gov.mn](mailto:ganbold@khovd.gov.mn) цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- ✚ Төрийн жинхэнэ албан тушаалд албан ёсоор томилогдсон байх;
- ✚ Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- ✚ Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх;

### Бүрдүүлэх материал:

- ✚ Төрийн албан хаагчийн анкет;
- ✚ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ✚ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- ✚ Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- ✚ Нийгмийн даатгалын дэвтэр (хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, цахим лавлагаа;
- ✚ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ✚ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас”-ны хуулбар;
- ✚ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ✚ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia–аас татан авах);

### Материал хүлээн авах:

- ✚ Хугацаа: 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- ✚ Хүлээн авах хаяг: [ganbold@khovd.gov.mn](mailto:ganbold@khovd.gov.mn)
- ✚ Холбоо барих утас: 99438912

### Мэдээлэл авах эх сурвалж:

- ✚ [https://hh.csc.gov.mn/?sector\\_id=02001048&offset=1&limit=10](https://hh.csc.gov.mn/?sector_id=02001048&offset=1&limit=10)
- ✚ [http://khovd.gov.mn/?page\\_id=17682](http://khovd.gov.mn/?page_id=17682)
- ✚ <https://e-mongolia.mn/home>
- ✚ <https://www.facebook.com/groups/1011120516311661> (ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ)

д/д	Байгууллага	Дотоод нэгж	Ажлын байрны нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо	Боловсрол	Мэргэжил	мэргэшил	Туршлага	Холбоо барих утасны дугаар	Цахим хаяг
<b>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН АЛБАН ТУШААЛ</b>											
1	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар	ТЗУХ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	ТЗ-2	1	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Эрх зүй, эдийн засаг, бусад	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх	99438912	<a href="mailto:ganbold@khovd.gov.mn">ganbold@khovd.gov.mn</a>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ